

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл

(Хөнгөлөлттэй зээл)

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд Монгол улсын үйлчилгээний салбар хөгжиж, газар доорх байгалийн баялаг, хөдөө аж ахуйн баялагт чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэж, Монгол улсад гадаадаас ирэх зорчигчдын тоо улам бүр өсөн нэмэгдэж байна. Ийм нөхцөл байдалд Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудал 2003 онд 200 мянган зорчигч хүлээн авсан бол 2014 онд 670 мянга болж, ойролцоогоор 3 дахин нэмэгдэж, ирээдүйд олон улсын нислэгийг голлосон хэрэгцээ өргөжин тэлэх хандлагатай байна. Нөгөөтэйгүүр одоогийн нисэх онгоцны буудал нь өмнөд, зүүн талаараа уулаар хүрээлэгдсэн тул газар зүйн хувьд хязгаарлагдмал,

салхины чиглэл зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан нислэг саатаж, нислэг хойшлох, нислэгийг цуцлах явдал ихээр гарч, аюулгүй байдал, итгэлийг нэмэгдүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна. Тиймээс Монгол улсын Засгийн газар олон улсын стандартад нийцсэн шинэ нисэх онгоцны буудал барихаар шийдэж, үүнд шаардлагатай хөрөнгийг Япон улсаас хүссэн билээ. Үүний дагуу Япон улсын Засгийн газар нийт 65 тэрбум 657 сая иенийн хөнгөлөлттэй зээл олгож, байгууламжийн бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэж, 2017 оны 1 сард барилгын ажлыг дуусган монголын талд хүлээлгэн өгсөн.

Агуулга

- Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлын барилга (Төв аймгийн Хөшигтийн хөндийд баригдсан)
Онгоц хөөрөх, буух зурвас (3600м х 45м, 1 замтай), туслах талбай (104200м²), зорчигчийн терминал (3 давхар, нийт талбай ойролцоогоор 30000м²), хяналтын цамхаг, нисэх онгоцны буудлын аюулгүй байдлын байгууламж, гал унтраах, аврах байгууламж, түлш цэнэглэх байгууламж зэрэг бусад нэмэлт байгууламжийн бүтээн байгуулалт.
*Япон улсаас Монгол улсад үзүүлсэн зээлийн нөхцөл (үндсэн зээл: 28 тэрбум 807 сая иен) зээлийн хүү: 0.2% (зөвлөх үйлчилгээ: 0.01%), нэмэлт зээл: 36 тэрбум 850 сая иен, зээлийн хүү 0,1% (зөвлөх үйлчилгээ: 0.01%), эргэн төлөлтийн хугацаа: 40 жил, үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 10 жил.



Барилгын ажил явагдаж буй зорчигчийн терминал



Шинэ нисэх онгоцны буудлын ерөнхий зураг

Үр дүн

Уг төсөл нь Улаанбаатар хотын нисэх онгоцны буудлын аюулгүй байдал, итгэлийг сайжруулж, тохь тухтай байдлыг хангаж, гадаад дотоодын ачаа тээвэрлэлтийн үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар төвтэй нийт Монгол улсын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх зорилготойгоор төлөвлөгдсөн.

Шинэ нисэх онгоцны буудал баригдсанаар 2019 онд 14500 олон улсын нислэг хүлээж авах боломжтой болж, олон улсын зорчигчийн тоо

140000 орчимд, олон улсын ачаа тээвэрлэлтийн хэмжээ 92000 тоннд хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна. Энэ нь одоогийн нисэх онгоцны буудлын хүчин чадлаас 2.5 дахин их юм.

Шинэ нисэх онгоцны буудал нь Япон, Монгол хоёр улсын найрамдлын шинэ бэлэг тэмдэг болж, ирээдүйд хоёр орны ард түмний хайр хүндлэлийг хүлээсэн газар болно хэмээн найдаж байна.